

**URGENT төслийн хүрээнд боловсруулж буй “ Хот суурингийн цэцэрлэгжүүлэлт”,
“Ландшафтын архитектурын төсөл-II” хичээлүүдийн хөтөлбөрт өгөх санал**

2022.09.13

ХААИС-ийн Агрэкологийн сургуулийн Таримал судлал, Ой, Ландшафтын архитектурын тэнхимийн багш доктор С.Одонгэрэлийн боловсруулсан “Хот суурингийн цэцэрлэгжүүлэлт” болон докторант А.Бэлгүүн багшийн боловсруулсан “Ландшафтын архитектурын төсөл-II” хичээлүүдээр оюутан сургах болон сурах үйл явц нь шавь товчтай сургалтын арга барилд тулгуурлах ба лекц, харилцан яриа, семинар, бие даалт, тайлан бичилт, судалгаа гүйцэтгэх, мэдээ цуглуулах, түүнд анализ хийх, илтгэл тавих гэх мэт олон хэлбэрээр холимог цахим хэлбэрээр 32 цагийн лекц, 32 цагийн лаборатори, 80 цагийн бие даалтын хичээл тус тус төлөвлөсөн нь бакалаврын түвшний шаардлагад нийцсэн байна. Суралцагседад онол практикийн ач холбогдолтой сэдэв, агуулга бүхий болсон нь хичээлийн хөтөлбөрийг үнэ цэнтэй болгожээ.

Эдгээр хичээлүүдийн стандарт хөтөлбөрүүд нь бакалаврын түвшний хичээлийн сургалтын стандарт хөтөлбөрт тавигдаж байгаа шаардлагыг бүрэн хангаж байгаа хэдий ч улам сайжруулах зорилгоор дараах саналуудыг тавьж байна Үүнд:

1. Хичээлийн зорилго, оюутанд олгох мэдлэг, чадварын талаарх тодорхойлолтын утга агуулгыг сайжруулан бичих;
2. Хичээлийн хөтөлбөрийн 4-р хуудас дахь хичээлд ашиглах ном, сурах бичгийн жагсаалтад мэргэжлийн болон холбогдох материал, эх сурвалжийг нэмэгдүүлэх;
3. Бие даалт эсвэл дадлагын хичээлд төлөвлөлтийн тусгай программууд дээр дадгаажуулж сургах;
4. Хот суурингийн цэцэрлэгжүүлэлт хичээлийн бие даалтаар ногоон байгууламжийн эрх зүйн асуудлууд, төлөвлөлтийн оновчтой шийдлүүдийг нэмж оруулах;
5. Ландшафтын архитектурын төсөл хичээлээр тухайн төслийн эдийн засгийн тооцоо, хэрэгжих үе шатууд болон төслийн үр дүнд тухайн байдалд ямар өөрчлөлтүүд гарах зэргээр түдхүү өйлгөлтыг өгөх зэрэг болно.

Санал бичсэн:

ХААИС, Агрэкологийн сургуулийн
Газрын менежментийн тэнхимийн зөвлөх проф. **Төмөрбаатарын БАЛЖИННЯМ**
Доктор(Ph.D), дэд профессор, МУ-ийн зөвлөх инженер Т.Балжинням

